

ЗУРГААН ТАЛТ ХЭЛЭЛЦЭЭРИЙН ЭРГЭН ТОЙРОНД

*Д.Золбоо**

Улиран одож буй 2006 онд дэлхий дахиныг донсолгосон томоохон үйл явдлуудын тоонд 10 сард өөрийн нутаг дэвсгэр дээрээ газар доорх цөмийн туршилт хийсэн Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улсын үйл ажиллагаа зүй ёсоор орж байна. Умардынхны энэ үйлдлийг хөрш зэргэлдээ улс орнууд төдийгүй дэлхийн олон нийт буруушаан зэмлэн хүлээн авсан билээ. Тухайлбал, аливаа Солонгосын хойгийн маргаанд тайвнаар хандаж ирсэн БНХАУ-ын зүгээс тэднийг “ичгүүргүй, олон улсын хамтын нийгэмлэгийн саналыг үл ойшоогч” гэж зэмлэхэд хүргэжээ. Пхеньяны цөмийн туршилтын хариуд Япон улс эдийн засгийн хориг арга хэмжээ авч, НҮБ цөмийн хөтөлбөрт ашиглаж болох технологи, бараа материал, цэргийн техникийг Умард Солонгост нийлүүлэхийг хориглосон тогтоол гаргасан билээ.

Гэвч энэ бүхэнд Пхеньянь Вашингтоны зүгээс дайсагнасан бодлогоо зогсоохгүй бол цөмийн хөтөлбөрөөсөө татгалзахгүй хэмээн удаа дараа мэдэгдсэн юм. Мөн тэдний Макао дахь банкны дансыг эргэн сэргээхийг шаардсан юм. Вашингтон энэхүү санхүүгийн хориг арга хэмжээг цуцлах талаар хоёр талын ажлын хэсэг байгуулж болох юм гэж зөвшөөрснөөр хэлэлцээрийн ширээний ард суухаар болжээ. Энэхүү бүс нутгийн улс төрийн маргааныг шийдвэрлэхээр хөрш зэргэлдээ ОХУ, БНХАУ, БНСУ, Япон зэрэг улсаас гадна АНУ-ын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнийг оролцуулсан зургаан талын хэлэлцээр явагддаг болсоор уламжлал болсон билээ. Солонгосын хойгийн цөмийн хямралын асуудлыг хэлэлцэх энэ удаагийн 6 талт хэлэлцээр 13 сарын турш мухардалд орон завсарласны эцэст 12 дугаар сарын 18-нд БНХАУ-ын нийслэл Бээжин хотноо Төрийн хүндэтгэлийн Дяоютай хурлын танхимд сэргэн 5 хоногийн турш үргэлжлэв. Бүс нутгийн төдийгүй дэлхий дахины энх тайван, аюулгүй байдалд нөлөөлөхүйц энэхүү үйл явцаас ямар шийдвэр гарахыг дэлхийн олон нийт чих тавин хүлээж байлаа.

Олон улсын мэдээллийн агентлагуудын мэдээлж байснаар гол маргаан, үл ойлголцол АНУ болон БНАСАУ-ын төлөөлөгчдийн хооронд өрнөсөөр, бие биедээ буулт хийлгүй, өөрийн улс төрийн байр сууриа хатуу баримталсаар байсныг дэлхийн олон мэдээллийн агентлаг тухай бүр нь уламжилж байлаа. Цөмийн зэвсэгтэй бусадгүрэн Умард Солонгосыг

* Д.Золбоо - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр

өөрсдийн ижил тэгш хамтрагч гэж үзэхийг шаардаж, цөмийн хөтөлбөрийг зогсоох бус харин зэвсэглэлийг хураах асуудлаар л ярилцах сонирхолтой байгаа зэрэг шаардлагуудаа тавьжээ. АНУ-ын зүгээс Умард Солонгосыг цөмийн хөтөлбөрөө зогсоосны дараа л харилцаагаа хэвийн болгох буюу буулт хийх болно гэсэн байр сууриндаа хатуу зогслоо. Эцсийн дүнд тодорхой хамтын шийдэлд хүрч, хүсэн хүлээсэн ахиц дэвшил авчиралгүй байсаар өндөрлөв. АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга К.Райсын хэлснээр “эцсийн үр дүнгүй, гэхдээ дэвшил гарсан” гэх үнэлгээ энэ удаагийн хэлэлцээрт хамгийн их тохирч байгаа ажээ.

Манай улсын хувьд дэлхийн олонх улсын нэгэн адил Солонгосын хойгийн цөмийн хямралын асуудлыг яриа хэлцлийн аргаар, энхийн замаар шийдвэрлэх байр суурийг баримталж байна

XX зууны хагаст БНМАУ-ыг хүлээн зөвшөөрч дипломат харилцаа тогтоосон ЗХУ-ын дараа орох хоёр дахь улс бол БНАСАУ байлаа. Өнөөдөр Монгол Улс, БНАСАУ-тай уламжлалт найрсаг харилцаагаа халгалсаар байна. Тухайлбал, хоёр орны Засгийн газар хооронд сүүлийн жилүүдэд Тээврийн салбарт хамтран ажиллах тухай (1996), Иргэн, гэр бүл болон эрүүгийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээ (1998), Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээ (2002), Эдийн засаг, худалдаа, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааны зөвлөлдөх комисс байгуулах тухай хэлэлцээр (2004) зэргийг байгуулан хоёр орны ард түмнүүдийн эрх ашигт нийцүүлэн өргөжүүлэхээр тохиролцон ажиллаж байна. Сүүлийн жилүүдэд хоёр орны хоорондын худалдааны хэмжээ нэмэгдсээр 200 орчим мянган доллар болж өсчээ. Мөн Монгол улсын иргэн визгүй зорчдог цөөн улсын нэг нь БНАСАУ юм. 2008 оны 10 сард дипломат харилцаа тогтоосны 40 жилийн ой тохиох бөгөөд хоёр талаас тэмдэглэн өнгөрүүлэх талаар ярилцаж байгаа ажээ.

БНАСАУ-ын дотоод улс төрийн байдлын талаарх зарим мэдээллийг Yonhap News мэдээллийн агентлагийн эрхлэн гаргадаг “Vantage Point” сэтгүүл, АНУ-ын Brookings Institution-ий судлаачдын нийтлүүлсэн сонирхолтой судалгааны өгүүлэлд тулгуурлан товч тоймыг судлаачийн зүгээс хүргэж байна.

БНАСАУ-ын “Нэгдүгээрт-арми” (Military-first)

улс төрийн бодлого түүний эргэн тойронд

Умард Солонгосын удирдагч Ким Чен-Ир 1995 оноос “Songun буюу нэгдүгээрт арми амжилт” уриатай улс төрийн бодлогыг хэрэгжүүлж эхэлжээ. Энэ нь нам төвтэй бүтэц аажмаар төрийн цорын ганц тулгуур

болох Үндэсний батлан хамгаалах зөвлөлөөр удирдуулсан цэргийн бүтцэд байр сууриа тавьж өгсөн гэж ойлгож болох юм. Өмнө нь бол (Умард) Солонгосын Ажилчдын нам нь БНАСАУ-ын хэмжээнд хамгийн нэр нөлөө бүхий удирдах дээд байгууллага байсан бөгөөд бүхий л төр захиргаа, аж ахуйн байгууллага тэр дундаа (Умард) Солонгосын Ардын Арми ч нэгэн адил багтдаг байжээ.

Ким Чен Ир өөрийн Солонгосын Ардын Армид (САА)-д анхаарлаа төвлөрүүлэх болсон гол учир шалтгааныг 1980-аад оны эцсээр хуучин Зөвлөлт Холбоот Улсын цэргийн хамгаалалтад байсан Зүүн Европ дахь коммунист дэглэмийн гэнэтийн сүйрэл гол сургамж болсон гэж үзэж болох юм. ЗХУ-ын анхны бөгөөд сүүлчийн ерөнхийлөгч М.Горбачев улс төрийн шинэчлэлийн хүрээнд Зүүн Герман болон бусад социалист орноос цэргээ татан гаргаж тэдгээр оронд өөрийн улс төр, эдийн засаг, цэргийн оролцоогоо зогсоохоор шийдэх үед дээрх улсад тогтож байсан улс төрийн дэглэм нь ардчилал, чөлөөт эдийн засгийн зах зээлийн системийн эсрэг сөрөн зогсож өөрийн үзэл бодол, нийгмийн зохион байгуулалтаа хадгалж үлдэж чадаагүй гэж үздэг ажээ. Тиймээс өнөөдрийн даяаршлын эрин зуунд улс төрийн тавцан дахь ганцаардлын үед Ким цэргийн хүчин бол улс төрийн намаас илүүтээр цэргийн хүчин нь БНАСАУ-ын үзэл бодол, үндэс угсаагаа хадгалан үлдэх цор ганц тулгуур болно гэж үзэж байна.

2002 оны 10 сард болсон пуужингийн хоёр дахь удаагийн хямралын үеэр Солонгосын Ардын Арми нь Умард Солонгосын хувьд зөвхөн батлан хамгаалагч төдийгүй харин ч БНАСАУ-ын улс төрийн шийдвэр гаргагч голлох хүчин болсныг дэлхий дахинд нотлон харуулсан юм. Цэргийн байгууллагууддаа ихээхэн анхаарал хандуулж байгааг зарим нэг мэдээллээс тухайлбал, Ким Чен Ир 2005 онд дотооддоо 79 газарт зочилж, ажил байдалтай танилцсанаас 66 нь ямар нэгэн байдлаар цэрэг, армийн холбогдолтой байгууллага байснаас харагдаж байгаа юм.

Энэхүү бодлогын талаар Умард Солонгосын албаны болон хэвлэл мэдээллээр зарим нэг тайлбарыг хийсээр ирсэн бөгөөд тухайлбал, Солонгосын ажилчны намын сонин болох Rodong Sinmun-ий саяхны дугаарт “Нэгдүгээрт-арми” (цэрэгжилт-амжилт) бодлого бол зөвхөн БНАСАУ төдийгүй Солонгосын хойг дахь нийт үндэстний аюулгүй байдал, тусгаар тогтнолын төлөөх илд зэвсэг болж буй талаар бичжээ. Гэвч энэхүү тайлбарын талаар БНСУ-ын холбогдох албаны зүгээс “Умардынхны зүгээс бидний аюулгүй байдалд туслаж, хамгаалах гол арга нь пуужингийн туршилтаа зогсоох, цөмийн хөтөлбөрөөсөө татгалзах юм” гэж удаа дараа хариу мэдэгдэж байв.

БНАСАУ-ын баримталж буй энэхүү улс төрийн бодлогыг судлаачид хоёр талтай тайлбарлаж байна. Тухайлбал, 1961 онд БНСУ-ын армийн хурандаа Пак Чун Хи цэргийн эргэлт хийж засгийн бүх эрхийг цэргийн эрхтэн дархтнууд гартаа авч улс орноо удирдан залж, улс төр эдийн засгийн зоримог шинэчлэл хийж байсан билээ. Эдүгээ олон нийтийн дунд генерал Пак-ыг “Өмнөд Солонгосын эдийн засгийн гайхамшгийн эцэг” гэж зарим талаар хүлээн зөвшөөрөх болсон. Нөгөө талаар Ким Чен-Ир сүүлийн үед хийсэн уулзалт, яриандаа Пак ерөнхийлөгчийн Өмнөд Солонгосын эдийн засгийн шинэчлэлд гүйцэтгэсэн үүргийн талаар олонтаа жишээ татан ярих болсон нь тохиолдлын хэрэг биш байж болох юм. Гэвч энэ хоёр бие хүн, тэдний үзэл бодол, үйл явцыг цаг хугацаа, гадаад, дотоод хүчин зүйлс зэргээс нь шалтгаалан шууд утгаар нь адилтган үзэх боломжгүй юм. Өмнөд Америкийн Чили, сүүлийн үед Пакистан, Тайланд зэрэг Азийн зарим улсад өрнөж буй улс төрийн үйл явц тодорхой жишээ болж болох юм.

Ким Чен Ир-ийн шинэ эхнэр болон өв залгамжлуулах төлөвлөгөө

Удирдагч Ким Чен Ир хоёр жилийн өмнө эхнэрээ өвчнөөр нас барснаас хойш өөрийн хувийн нарийн бичгийн дарга бүсгүйтэй цуг амьдарч буй талаар мэдээлэх болжээ. Албан эх сурвалжид энэ жил 42 нас хүрч буй Ким Ок бүсгүйг улс орны тэргүүн хатагтайн байр сууринд нэгэнт очсон болон улс орны тэргүүний цэрэг арми, үйлдвэр үйлчилгээний газруудад зочлоход дагалдан явдаг төдийгүй гадны өндөр дээд хэмжээний зочид төлөөлөгчидтэй уулзахад оролцдог болсон талаар мэдээлж байна. Түүнчлэн энэ оны 1 дүгээр сард Ким Чен Ир-ийн БНХАУ-д хийсэн нууц айлчлалын үеэр Хятадын удирдагч Ху Жиньтаотай хийсэн уулзалтад тэргүүн хатагтайн байр сууринаас оролцсон талаар мэдээлжээ. Одоогоор олдож буй баримтаас үзвэл Ким Ок бүсгүй БНАСАУ-д нэр хүнд бүхий Пхеньяний Хөгжим бүжгийн их сургуулийг төгссөн бөгөөд 1980-аад оны эхээс Ким Чен Ир-ийн хувийн нарийн бичгийн даргаар ажиллажээ. Энэ бүсгүйн мэдлэг боловсрол, зан аашийн талаар түүний ойрын хүрээнийхэн ам сайтай байгаа хэдий ч энэ хоёрын дундаас төрөх хүүхэд төрийн тэргүүний өв залгамжлагчаар тодрох магадлал байхгүй байгаа юм.

Өмнөд Солонгос болон Японы хэвлэлүүдэд бичиж байгаагаас үзвэл Ким өөрийнхөө өв залгамжлагчаар өмнөх эхнэрүүдээсээ төрсөн гурван хүүгийн нэгнээр тавих магадлал өндөр байгаа ажээ. Эх сурвалжууд

сүүлийн жилүүдэд тэдгээр гурван хүү болон тэдний хүрээлэгчдийн дундах өрсөлдөөн ихэд ширүүсч байгаа талаар мэдээлэх болжээ. Ким Чен Ир эцэг Ким Ир Сенийг 1994 онд зүрхний өвчнөөр нас барахад түүний өв залгамжлагч болж төрийн тэргүүний орыг эзэлсэн нь коммунист орны түүхэн дэх анхны тохиолдол болсон билээ. Энэ оны 2 дугаар сард 64 нас хүрсэн Кимийн намтарт 3 бүсгүйг өөрийн албан ёсны эхнэр болгож байсан гэж бичдэг байна. Гэвч тэрээр амьдралынхаа туршид жүжигчин, дуучин болон бүжигчин зэрэг олон бүсгүйчүүдтэй нэр холбогдож байсан нь одоо нэгэнт нууд биш болжээ. Түүний сүүлчийн эхнэр Ко 2004 оны 6 сард хөхний хорт хавдрын улмаас нас барсан бөгөөд бүжгийн чуулганд ажиллаж байхдаа Кимийн нүдэнд өртөж танилцаж байжээ. Хатагтай Ко хоёр хүү төрүүлсэн бөгөөд тэд нь энэ жил 25 настай Жон Чол, 22 настай Жонг Ун нар юм. Хойд Солонгосын ажиглагчдын үзэж байгаагаар Жон Чол бол өөрийн эцгийн өв залгамжлагчаар тодрох магадлал өндөр гэж үзэж байгаа хэдий ч зарим мэдээллийн хэрэгслийн үзэж буйгаар түүнийг эцэг нь ажил төрөлдөө хэтэрхий “охин шиг” ханддаг гэж голдог гэжээ. Энэ тохиолдолд түүний дүү Жон Унд эцгийнхээ орыг залгах боломж тодорхой хэмжээгээр нэмэгдэж байгаа ажээ.

Москва хотноо 20 гаруй жил амьдарч байгаад 2002 онд нас барсан Умард Солонгосын кино од Сун Харим-ийг Ким Чен Ирийн анхны эхнэр гэж үздэг байна. Удаан хугацаанд хамт амьдарч чадаагүй боловч өөрийн эцэг Ки Ир Сенээс нууцаар харилцаж байжээ. Хатагтай Сун бол Кимийн хамгийн том хүү болох 35 настай Жун Нам-ийн эх юм. Энэ залуу олон жилийн турш Ким-ийн өв залгамжлагчаар тодрох магадлалтай талаар яригдаж байсан боловч хэт дураараа амьдралынхаа хэв загварын улмаас эцгийнхээ итгэлийг алдсан юм. Тэрээр 2001 онд Доминикан улсын хуурамч паспортаар Японд нэвтрэх гэж байгаад хил дээр баригдаж байжээ. Тэрээр өөрийнхөө аялалынхаа зорилгыг Токио дахь Диснейлэнд-эд зочлох хүсэлтэй байсан гэж цагдаагийн байгууллагад мэдэгдэж байжээ.

1970-аад оны сүүлээр Ким Чен Ирийг Сунтай амьдарч байх үед түүнийг эцэг нь өндөр тушаалын армийн офицерийн охин Ким Ёнсуктай гэрлүүлжээ. Тэд 2 охинтой бөгөөд 33 настай Сол Сонг, 31 настай Чун Сонг нар юм.

Энэ бүгдээс дүгнэлт хийж үзвэл 70 нас дөхөж яваа Ким Чен Ир өөрийн залгамжлагчийн талаар ихээхэн анхаарал хандуулж буй ажээ. Шинжээчдийн үзэж буйгаар цөмийн хөтөлбөр, пуужингийн туршилтаас үүдсэн хэрэг явдлын улмаас энэ асуудал хэсэг хугацаанд хойшлогдоод

байна. Мөн тодорхой болж шийдэгдсэн байлаа ч Умард Солонгосын тал энэ асуудлын талаар олон нийтэд тэр бүр шуурхай мэдээлэхгүй байж болох ажээ.

Социалист системийн орнуудад өөрийн ойрын төрөл садангаас өв заламжлагчаа тодруулж, улсын удирдагчаар сонгох явдал уламжлал болж байгаа нэгэн жишээ бол энэ оны 7 дугаар сарын 31-нд энэ жил 80 нас хүрч буй Кубын ерөнхийлөгч Фидель Кастро өвчний улмаас төрийн эрх мэдлээ өөрийн дүү Батлан хамгаалах яамны сайд Рауль Кастрод шилжүүлсэн явдал ажээ. Ер нь энэ хоёр улсын хувьд дотоод нийгмийн амьдрал төдийгүй, улс орны гадаад харилцааны хувьд төстэй зүйл багагүй бөгөөд хоорондын харилцааны өвөрмөц шинж чанар бий. Кубын удирдагчийн 1986 онд Пхеньянд айлчлахдаа байгуулсан 2 талын цэргийн салбарт хамтран ажиллах гэрээний 20 жилийн хугацаа энэ онд дуусч байгаа бөгөөд аль нэг талаас санал гараагүй тохиолдолд дахин 10 жил сунгах ажээ. Гэвч одоогоор хоёр улсын энэ салбарын хамтын ажиллагааны ирээдүй ихээхэн бүрхэг байгаа юм. Дэлхийн томоохон хэвлэл мэдээллийн хэрэгслийн мэдээлж байгаагаас үзвэл удирдагчийн үүрэг гүйцэтгэж буй Рауль улс орондоо зарим нэгэн өөрчлөлтийг хийхээр төлөвлөж байгаа талаар мэдээлж байна. Удирдагч солигдоход улс төрийн бодлого дагаад өөрчлөгддөг Кубын энэ жишээнээс харахад тодорхой хугацааны дараа Умард Солонгост ч гэсэн зарим нэгэн өөрчлөлт гарах нь гарцаагүй биз ээ.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Alexander V. Vorontsov, "North Korea's Military-First Policy: A Curse or a Blessing?" Center for Northeast Asian Policy Studies, The Brookings Institution, 2006
2. Prof. Ho-Yeol Yoo. "North Korea's Military-first Politics and its implications for inter-Korean relation" Vantage Point, vol 29 #9. September 2006
3. "Kim Jong-Il's new wife and succession plan" Vantage Point, vol 29 #8. August 2006
4. Hyun Seong-il "Changes in North Korea's State Strategy in the Kim Jong-il Regime" Vantage Point, vol 29 #9. September 2006
5. Kim Sung-jin "Relations between North Korea and Cuba" Vantage Point, vol 29 #9. September 2006